

**МОНГОЛЫН ЛАМАЙЗМ БА ВЬЕТНАМЫН  
THIEN TONG (MEDITATION SECT OF BUDDISM)  
ШАШНЫ НИЙТЛЭГ БА ЯЛГААТАЙ ТАЛ**

*Као Суан Фо\**

Монголын шарын шашин /ламайзм/ ба вьетнамын thien tong шашны уг гарвал нэг бөгөөд Нагаржунайн сургаалд суурилжээ. Нагаржунай бол нийтийн тооллын II ба III зууны заагт өмнөд Энэтхэгт тодорсон Буддын гүн ухааны хамгийн нэр нөлөө бүхий онолч мэргэдийн нэг билээ. Тэрбээр Их хөлөгний голлох үзэл болох Төв үзлийн (madhyamaka) сургаалыг онолын үүднээс үндэслэн боловсруулжээ. Түүний гол бүтээл нь төв үзлийн онолын үндсийг хураангуйлан гаргасан “madhyamakaruka” болон билэг билгийн номнол “mahaprajnaparimita-sastra” тэргүүтэн болой.

Түүний гол гавьяа нь эртний мэргэдийн номлол “mahaprajnaparimita” судрын сургаал дахь бурханы шашны үзэл агуулгыг системтэй гүн гүнзгий тайлбарласанд оршино. Өөрөөр хэлбэл бурханы шашны билэг барамидын ном судрын онолын үндсийг уламжлан авч нягтлан цэгцэлж гүнзгийрүүлэн хөгжүүлжээ. Тэрбээр ертөнцийн бүх юмс, үзэгдлийг хоосон чанартай хэмээн үзэж, чингэхдээ туйлаас байхгүй биш, харин харьцангуй оршин байдгийг нотлон өгүүлжээ. Тэгснээр олон үеийн турш зэрэгцэн байсан “төгс буй” буюу “төгс үгүй” хэмээх өрөөсгөл ухаарлыг няцаасан төв буюу дундад үзлийг бий болгожээ. Энэ үзлийн үүднээс үзвэл хэрвээ эсрэг тал нь байхгүй бол тэр өөрөө бас байхгүй, өөрөөр хэлбэл үхэх төрөх, ирэх одох, байх байхгүй гэх мэт эсрэг тэсрэг чанарууд нь аливаа юмны оршин байх түгээмэл шинж хэмээжээ. Энэ үүднээс ертөнцийн бүх юмс үзэгдлийн дотоод гол чанар тэдгээрийн орших гол байдлыг илэрхийлж буй категорийг хоосон чанар (sunyata) хэмээн үзжээ.

Бидний өмнө юмс үзэгдэл харагдаж, мэдрэгдэж байгаа нь үнэн. Гэвч тэр үнэн бол ердийн ухамсрын түвшин дэхь янагуух харьцангуй үнэн болохоос биш туйлын үнэн биш. Туйлын буюу чанагуух үнэн нь тэр юмс үзэгдлийн байх байхгүй, орших эс оршихуйн дундах байнгын чанар буюу хоосон чанарт оршино. Тэр хоосон гэдэг нь сэтгэл бөгөөд төгс амгалант сэтгэл юм.

Нагаржунайн сургаал ёсоор бол нирваан (nirvana) гэдэг нь хүрч болшгүй зүйл биш бөгөөд үзэгдлийн мөн чанарт шингэн орж буй хэрэг. Энэ нь thien буюу дияаны шашны онолын үндэс юм.

---

\*Као Суан Фо - БНСВУ-ын Зүүн Өмнөд Азийн Хүрээлэнгийн профессор

Төв үзэл бол ламайзмын гурван гол сургаалын нэг. Нөгөөх хоёр нь uogachara буюу ёгынхон (ёгын аргатанууд) хийгээд vajrayana юм.

Ёгийн сургаалыг үндэслэгч нь нийтийн тооллын IV зуунд умард Энэтхэгт төрсөн Асанга бөгөөд төв үзлийн цаашдын хөгжилд сүрхий нөлөө үзүүлжээ. Энэ чиглэлийг баримтлагчид зөвхөн санаа ухамсрыг бодитой хэмээн үзээд гадаад ертөнцийг түүний зөвхөн хэлбэр төдий зүйл гэх ба оюун сэтгэл (vijñana) бүхнээс үнэн хэмээн үзнэ. Бодит юм байна гэдэг нь түүний хэлбэрийг олсон оюун санааны үр дүн гэх бөгөөд бидний оюунд байгаа юмыг л бид ертөнцөөс олж үзнэ хэмээн үздэг. Энд санаа бодит юм хоёр салшгүй ажээ. Ухамсарлах чадвар (perception) байна гэдэг нь хүн болгонд тусгай мэдрэмж буюу дотоод чадавхи байна гэсэн үг бөгөөд мөн аливаа бодьгал хийгээд юмст оршин өөрийгөө илэрхийлэгч эх үндэс Alayavijñana байна гэсэн үг хэмээн үздэг. Хотлын шүтээн буюу Alayavijñana нь дотоод сэтгэлийн наймдах мэдрэмж бөгөөд нөгөөх долоон мэдрэмжээ багтаан барьж байдаг.

Alayavijñana нь усны урсгал мэт байнгын хөдөлгөөнтэй бөгөөд хүний сэрэхүйд өөрчлөгдөн хувирч байдаг. Нөгөөх долоон мэдрэмж түүнийг заримдаа далдлан бүрхэх учир оюун сэтгэлээр онон барих амаргүй бөгөөд түүнийг онон барих аваас хоосон чанарыг ухаарч бодь сэтгэлийг олно хэмээн үздэг ажээ.

Ламайзм нь sarvastivada болон vajrayana сургаалтны сахил жаягийн аль алиныг хэрэглэнэ. Түүний дотроос онох сэтгэлийн дээд туйл нь abhisheka авах ёс бөгөөд гүрү багшийн хувилгаан чадлын хүчээр доод төрөлтөн ном бясалгал хийж бурхан бодьсалва болж нирваан дүрийг олж болохыг заажээ. Хэдийгээр ламайзмын эх суурийг нийтийн тооллын VIII зууны үед эх багш Padmasambhava тавьсан боловч Юан гүрний үед сахьяа-гийн их ламтан Пагба (1235-1280) монголд дэлгэрүүлж авай. Дараа нь их ламтан Богд Зонхов (1357-1419) ламайзмд шинэчлэл хийж gelugpa буюу шарын шашныг бий болгосон нь умард Ази дахь монгол оронд өнөөг хүртэл халгалагдан хөгжиж иржээ.

Зонховын шашин үүсэхдээ Нагаржунайн билгийн чанад хүрэх оюун ухааны онол prajñāpāramitā болон sarvastivada сургаалтны Abhidharma буюу илт номын ухаан, винайн ёс /vinaya/ буюу номгоптохуйн ухааныг үндэс болгожээ. Шарын шашныг үндэслэгч Богд Зонхов нь Maṅgala буюу Майдар бурханыг шүтээн болгон тахиж түүний онцгой дүрийг бий болгожээ.

Ламайзмын тухай ийнхүү нуршин өгүүлсэний учир бол Вьетнамын thien tong шашин болон Монголын бурханы шашинд буй адил төстэй болон ялгаатай талуудыг олж харах гэснийх билээ.

Вьетнам оронд бурханы шашин нийтийн тооллын эхээр Өмнөд Энэтхэгээс орж ирсэн. Вьетнамын сурвалж бичигт тэмдэглэснээр нийтийн тооллын III зууны эхээр Төв Азийн Согдын орноос Kang Sen Houei гэгч дияанч ламтан тэр үеийн Giao Chau буюу умард вьетнамд ирж нутагшаад билэг брамидийн хамгийн эртний Ashtasahasrika судрыг орчуулан тархаажээ. Чухамхүү энэ судрыг шүтэн Нагаржуна өөрийн алдарт Madhyamaка буюу төв үзлийн онолыг үндэслэсэн бөгөөд тэр нь ялангуяа XII-XIII зууны үед вьетнамын бурханы шашинд гүн гүнзгий нөлөөлжээ. Мөн нийтийн тооллын III зууны дундуур Төв Азийн Кушаан орноос Kalaruci хэмээх дияанч лам Giao chau (умард вьетнамд)-д ирж дотоод сэтгэлийн дээд бясалгалыг номлосон Saddharma-samadhi хэмээх судрыг орчуулж авай. Ийнхүү бясалгалын ухаан вьетнам оронд дэлгэрэн хөгжиж нийтийн тооллын V зуун гэхэд вьетнамын олон дияанч нар нэрд гарч тэдний зарим нь Дундад улсын хааны урилгыг авч Хятад оронд бясалгалын ухааныг сурталчилан таниулж байв. Энэ үеийн вьетнам дияанч нар Нагаржунайн онол сургаал бүхий Өмнөд Энэтхэгийн dhyana-ы урсгал чиглэлийнхэн байв. Тийм учраас Нагаржунайн байр суурь нэн өндөр байсан юм. XVIII зууны үед бүтээгдсэн вьетнамын Tay Phuong хэмээх нэгэн сүмд (Hataу мужид) dhyana-ы сургаалыг залгамжлагч 18 үеийн дияанч нарын баримал байдаг бөгөөд түүний дотор зөвхөн Нагаржунайн баримал бурханы суудал буюу балма цэцгийн суудалд заларсан байдаг нь үүнийг илтгэнэ.

Нийтийн тооллын VI зууны үед амьдарч агсан Өмнөд Энэтхэгийн дияанч ламтан Vinitaruci умард вьетнамд ирж Өмнөд Энэтхэгийн дияаны Tynida урсгалыг тархаажээ. Энэ урсгал нь Нагаржунайн “8 үгүй” (Eight negations) буюу хоосон чанарын сургаалд мөн түшиглэсэн байх ажээ. Ийнхүү III зуунаас VI зуун хүртэлх вьетнамын thien tong шашинд Нагаржунайн төв үзэл ялангуяа Нагаржуна, Асанга нарын билэг брамидийн онол сургаал гүнзгий нөлөөлсөн нь ажиглагдана.

Vinitaruci-ийн чиглэлийн дияанч нараас олон ламтан шашныхаа хүрээнд нэр төрөө мандуулж байсан төдийгүй хаан төрийн дээгүүр алба хашиж байсан баримт олон бий.

Vinitaruci-ийн чиглэлийнхний нэр нөлөө XIX зууныг хүртэл өндөр байв. Үүнээс гадна Vo Ngon Thong (Awakened Without Speech) хэмээх

дияаны чиглэл вьетнамд IX зуунаас XV зууныг хүртэл байв. Энэ чиглэл Өмнөд Хятадаас гаралтай бөгөөд гол онол сургаал нь:

“Special transmision outside the orthodox teaching  
Nondependence on Sacred Writings

Direct pointing to the humanheart (leading to) realization of one's own nature (and) becoming a Budha” хэмээх хэдэн мөрт багтана. Хэдий тийм боловч хөгжлийнхөө явцад Хотлын шүтээн буюу Alayavijnana онол бүхий ёгийнхний нөлөө гүн гүнзгий туссан чиглэл юм. Энэ чиглэлийнхэн мөн л нэр хүндийг олж байсан бөгөөд түүний олон лам хувраг XI зуунд шашин төрийн өндөр албанд зүгтэж байв. Мөн Жампа /одоогийн өмнөд Вьетнамд байсан улс/ орны нэгэн дияанч ламтан XI зуунд Thao Duong хэмээх чиглэлийг үүсгэн хөгжүүлсэн. Энэ нь тантризм ба күнзийн сурталын аль алиныг тусгасан дияаны чиглэл байв. Энэ чиглэлийг тухайн үеийн вьетнамын олон хаад ноёд шүтэн дагаж байв.

Дээр дурдсан гурван төрлийн дияаны чиглэлийнхэн нэгэн цаг үед бие биендээ гүн гүнзгий нөлөө үзүүлж байснаас гадна энэтхэгийн дияаны сургаал, хятадын зэн буддизм, тантризм зэрэг олон онол сургаалын нөлөөгөөр улам баяжин хөгжсөөр ирсэн боловч өнөөг хүртэл вьетнамчуудын оюун санаанд хамгийн гүнзгий нөлөө үзүүлсэн нь Truc Lam хэмээх дияаны урсгал авай. Үүнийг XIII зууны үед вьетнамын хаан Tran Nhan Tong (1258-1308) 41 насандаа үндэслэн хөгжүүлсэн юм. Вьетнамын Truc Lam дияаны сургаал XVII зууныг хүртэл нэн хүчтэй хөгжжээ. Энэ урсгалын онцлог гэвэл Don giao (Sudden enlightenment teaching) болон Thiemgiao (gradual enlightenment teaching) хоёрын хосолмол шинжтэйгээс гадна Amithaba бурханыг гол болгож түүнд залбиран Сугаабалын оронд очиж амар амгаланг үзэхийг гуйн мөргөдөг. Мөн гал усаар ариутгал үйлдэж Mahasitatapatra тарнийн ид шид, Vajrasamadhi шүтэгч билэг брамидийн ёсыг эрхэмлэдэг.

Вьетнамын шашин хийгээд үндэсний соёлын үндсэн онцлог гэвэл будда бурханы ёс суртахууныг гол болгон залбирч нийгмийн суртахууны суурь болгодогос гадна бурханы шашин, бомбын шашин, күнзийн суртал гурвын хил зааг нэн бүдгэрч бие биендээ сүлэлдэн найрсан байдаг.

Вьетнамын бурханы шашин түүний дотор thien tong буюу dhyana урсгалын нийгэмд эзлэх байр суурь XV зуунаас эхлэн буурч ялангуяа нийгмийн дээд давхаргад күнзийн суртал давамгайлах болжээ.

Вьетнамын thien tong шашин үзэхдээ зүрх сэтгэлийн дотор бурхан оршино. Зургаан зүйл хамаг амьтан бүгд бурханлиг бөгөөд өөртөө Buddhahood-ийг агуулна. Хүн нүгэл үйлдэж бузартах аваас бурханлиг

чанар нь бүдгэрч түүнээсээ болж зовлонг болно. Зовлонг хүн өөрөө бий болгоно. Энд зовлонг гэтлээ гэвэл өөрөө өөртэйгөө тэмцэж, өөрөө өөрийнхөө зовлонгоос ангижрах ёстой. Энэ бол thien tong шашны гол сургаал. Энэ нь бас бурхан багш өөрөө бодьсатва болсныхоо дараахан айлдсан анхны онол сургаал нь. Үүнээс үзвэл өөрөө өөрийн хүч оюун ухаанд түшиглэх сургаал тэр үеэс үүдэлтэй бөгөөд Бурханы болон Thien Tong шашны нөлөөгөөр эртний болон эдүгээгийн вьетнам хүний сэтгэлгээний нэг гол онцлог нь өөрийн хүчинд тулгуурлахыг чухалчлах явдал болжээ. Үүнийг вьетнамын хэдэн мянган жилийн үүх түүх батална.

Дээр дурдсанаас үзвэл вьетнамын thien tong шашин, монголын ламайзм буюу шарын шашны сургаалд адил төстэй нийтлэг зүйл бишгүй байгаа нь үүсэл гарвал нэгтэйн учраас билээ. Өөрөөр хэлбэл Өмнөд Энэтхэгийн их багш Нагаржуна, Асанга нарын билэгбрамид Alaya-vijana сургаалын үзэл санаанаас үүдэлтэй. Гэвч бурханы шашны хоёр өөр урсгал болох ламайзм ба thien tong шашин аль аль нь өөр өөрийн хөгжлийн замаар явжээ. Ламайзм нь Vajrayana сургаалын нөлөөг илүү тусгаж амьд бурхад-гэгээнтэн Рембүчи, Далай лам нарыг бий болгосноос гадна Их хөлөгнийхөний дотор өргөн дэлгэрсэн хурал ном хуруулж, мандал өргөх, тарни шившлэгийн ид шидээр засал хийлгэн нүгэл хилэнцийг ариусгах дэг ёс ихэд дэлгэрчээ.

Харин вьетнамчууд бусдын ид шидийн хүчинд итгэхээсээ илүү өөрийн хүчээр сэтгэлээ ариусгаж өөрөө өөрийгөө аврах сэтгэлгээтэй бөгөөд түүнд вьетнамын thien tong шашны сургаал гүнзгий нөлөөлсөн байна. Хэдий тийм боловч вьетнамчуудын сүсэг бишрэлд тантризмын үзэл санаа ямар нэг хэмжээгээр нөлөөтэй бөгөөд вьетнамын олон сүм хийдэд төрөл бүрийн дарь эхийн барималууд байдаг.

Хэдийгээр ламайзм ба thien tong шашны хооронд нийтлэг ба ялгаатай талууд ийнхүү байдаг ч эдгээр шашны эрхэм дээд зорилго нь хүний зүрх сэтгэлийг ариусган зургаан зүйл хамаг амьтны тусын тулд буяныг арвижуулахын тулд болой.

*Вьетнам хэлнээс орчуулсан С.Дашцэвэл (ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор /Ph.D./)*